



# МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2017 ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

## I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2017 оны 4 дүгээр улиралд 596 сая ам.долларын алдагдалтай гарсан ч санхүүгийн данс 1,789 сая ам.долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 1,258 сая ам.долларын ашигтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 65 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 633 сая ам.доллараар, санхүүгийн дансны ашиг 1635 сая ам.доллараар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 3,008 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 8.0 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

## Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10% -иар өсч 2,721 сая ам.долларт хүрсэн бөгөөд барааны худалдааны тэнцэл 322 сая ам.долларт хүрч, сүүлийн 14 улирал дараалан ашигтай гарч байна. Үүнд СИФ нөхцөлөөр тооцсон нефтийн импорт 2017 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 40 сая ам.доллараар (23%), хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 168 сая ам.доллараар (45%) өссөн хэдий ч нүүрсний экспорт 100 сая ам.доллараар (122%), зэсийн баяжмалын экспорт 66 сая ам.доллараар (120%), ноолуурын экспорт 58 ам.доллараар (286%) өссөнөөр худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

## Үйлчилгээний худалдаа

2017 оны 4 дүгээр улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 19%-иар буюу 69 сая ам.доллараар өсч 431 сая ам.долларт хүрсэн байна. Энэхүү алдагдлын өсөлтөд бусад үйлчилгээний дансны алдагдал 29 сая ам.доллараар, аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал өмнөх оноос 27 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

## Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 544 сая ам.долларын алдагдалтай гарч алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 107%-иар буюу 281 сая ам.доллараар өссөн.


Тайлант улиралд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 75 сая ам.доллар, ногдол ашигт 47 сая ам.доллар, хөрөнгө оруулагчдын зээлийн хүүгийн төлбөрт 74 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 124 сая ам.доллар, харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 22 сая ам.доллар төлсөн байна.

## Хоёрдогч орлого


Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2017 оны 4 дүгээр улиралд манай улс нийт 49 сая ам.доллар буюу өнгөрсөн оны мөн үеэс 13.3 сая ам.доллараар бага орлогыг хүлээн авсан байна. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан гуйвуулга өмнөх оны мөн үеэс 11.0%-иар өссөн бол гадаад руу шилжүүлсэн иргэдийн гуйвуулга 32.6%-иар буурсан.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 1%-иар буурсан байна.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл



Дүрслэл 2. Барааны худалдаа



Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2017, IV улирал (улсаар, мян ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	31,150	57%	▲ 79%	1,609	8%	▼ -1%
Америк	8,332	15%	▲ 10%	2,998	16%	▼ -48%
Хятад	735	1%	▼ -61%	1,989	10%	▼ -32%
Гонг Конг	556	1%	▼ -21%	204	1%	▼ -40%
Англи	2,442	4%	▼ -37%	951	5%	▲ 165%
ОХУ	1,216	2%	▲ 66%	2,664	14%	▲ 37%
Сингапур	582	1%	▲ 13%	416	2%	▲ 68%
Швейцарь	1,058	2%	▲ 5x	63	0%	▲ 23x
Герман	1,512	3%	▲ 43%	682	4%	▲ 15%
Япон	833	2%	▼ -15%	517	3%	▼ -3%
Бусад	5,950	11%	▼ -57%	7,243	37%	▼ -46%
<b>НИЙТ</b>	<b>54,365</b>	<b>100%</b>		<b>19,335</b>	<b>100%</b>	

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2017 оны 4 дүгээр улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 792 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 303 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 489 сая ам.долларын орох урсгалтай байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 345 сая ам.доллараар өссөн байна. Энэ нь хөрөнгө оруулагчийн зээлийн ашиглалт өссөн болон компаниудын ашигт ажиллаатай холбоотой байв.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг улсаар нь авч үзвэл:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 161 сая ам.доллараар өсч 400 сая ам.доллар,
- Голлоанд улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 66 сая ам.доллараар өсч 67 сая ам.долларт хүрсэн,
- Люксембург улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 17 сая ам.доллараар буурч 20 сая ам.доллар,
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 11 сая ам.доллараар буурч 48 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 2017 оны 4 дүгээр улиралд уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн оны гүйцэтгэлээс өссөн үзүүлэлттэй байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал,

- Уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 228 сая ам.доллараар,
- Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 102 сая ам.доллараар,
- Барилгын салбар 21 сая ам.доллараар тус тус өссөн.
- Харин санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 9 сая ам.доллараар,
- Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 4 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

## Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2017 оны 4 дүгээр улиралд 393 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 416 сая ам.доллараар өссөн байна.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Засгийн газрын олон улсад гаргасан Гэрэгэ бондын ашиглалттай холбоотойгоор 800 сая ам.доллараар өссөн,
- Чингис бондын үндсэн болон хүүгийн төлбөрт 378 сая ам.долларыг буцаан төлсөн,
- Дим сам бондын эргэн төлөлтөд 14 сая ам.долларыг төлсөн.
- Банк ,аж ахуйн нэгж бондын хүүгийн төлбөрт 25 сая ам.долларыг төлсөн байна.

## Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд буюу бусад бүх төрлийн зээл (арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны зэрэг), бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын данс 923 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал тэнцэл 801 сая ам.доллараар өссөн дүнтэй байна. Энэхүү өсөлтөд Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн ашиглалт голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	IV улирал		2017.IV/16.IV	
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	Австрали	8.1	1%	5.3	▲
2	Америк	70.3	9%	51.6	▲
3	Англи	8.8	1%	7.5	▲
4	БНХАУ	48.4	6%	-11.0	▼
5	Герман	26.3	3%	24.3	▲
6	Голланд	66.8	8%	66.8	▲
7	Гонг-Конг	15.9	2%	-10.8	▼
8	Канад	399.5	50%	161.1	▲
9	Люксембург	20.0	3%	-17.0	▼
10	ОХУ	1.6	0%	0.4	▲
11	Сингапур	43.2	5%	22.8	▲
12	Солонгос (өмнөд)	5.6	1%	0.9	▲
13	Турк	0.5	0%	-0.3	▼
14	Франц	5.9	1%	3.3	▲
15	Япон	40.8	5%	18.0	▲
16	Бусад	30.4	4%	21.7	▲
<b>Нийт</b>		<b>792.1</b>	<b>100%</b>	<b>344.6</b>	<b>▲</b>


Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	IV улирал		2017.IV/16.IV	
		2016	2017	Өөрчлөлт	
1	Барилга	14.6	35.2	20.6	▲
2	Боловсрол	0.5	0.1	-0.5	▼
3	Боловсруулах үйлдвэрлэл	4.5	1.3	-3.2	▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	47.5	149.3	101.8	▲
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.9	0.3	-0.5	▼
6	Мэдээлэл, холбоо	0.5	1.8	1.4	▲
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.8	1.3	-1.4	▼
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	30.8	22.0	-8.8	▼
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.6	0.1	-0.6	▼
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.0	1.8	1.8	▲
11	Уул уурхай, олборлолт	324.0	552.7	228.7	▲
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12.8	9.2	-3.5	▼
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4.7	4.1	-0.6	▼
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.2	0.6	-0.6	▼
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.3	9.0	8.6	▲
16	Бусад	1.9	3.3	1.4	▲
<b>Нийт</b>		<b>447.5</b>	<b>792.1</b>	<b>344.6</b>	<b>▲</b>

Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт



## II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2017 оны 4 дүгээр улирлын эцэст цэвэр дүнгээр 31,553 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 5,606 сая ам.доллар байна. Үүний 54%-ийг гадаад валютын албан нөөц, 33%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг шууд хөрөнгө оруулалт, 5%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 37,158 сая ам.долларт хүрчээ. Үүний 46%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 40%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 14%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 7%-иар буюу 2,200 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг

- Ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 30%-иар буюу 1,296 сая ам.доллараар, гадаад пассив 10%-иар буюу 3,496 сая ам.доллараар тус тус өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 946 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын позиц 1,342 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын позиц 1639 сая ам.доллараар тус тус буурснаар, харин санхүүгийн үүсмэл хэрэгслийн позиц 15 сая ам.доллар, албан нөөц 1,712 сая ам.доллараар тус тус өссөнөөр тайлбарлагдаж байна.
- Тайлант улирлын позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар -531 сая, үнийн өөрчлөлтөөр -53 сая, бусад өөрчлөлтөөр -61 сая, ханшийн зөрүүгээр -72 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

### Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 56%-ийг буюу 9,673.2 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 44% буюу 7,572 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 4,837 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 28%,
- БНХАУ-аас 4,343 сая ам.доллар буюу 25%,
- Сингапур улсаас 1,550 сая ам.доллар буюу 9%,
- Хонг Конг улсаас 947 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 6%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтуудыг тус тус оруулсан байна.

### Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2017 оны 4 дүгээр улирлын эцэст 260 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 7%-иар буурсан бол гадаад пассивын үлдэгдэл 4,954 сая ам.долларт хүрч 36%-иар өссөн үзүүлэлттэй байна.


**Актив:** Эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Гонг конг 41%, Сингапур болон АНУ тус тус 14%, Англи 8%, Австрали 5%-ийг тус тус эзэлж байна.

**Пассив:** Эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал АНУ 16%, Лексембург 13%, Англи 8%, Сингапур 6%, Хонг Конг 4%, бусад улс 11%, харин 42% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа буюу хөрөнгө оруулагч улсыг тодорхойлох боломжгүй үнэт цаас эзэлж байна.


Хүснэгт 4. Позитц (сая ам.доллар)

Үзүүлэлт	16.12.31	17.12.31	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Гадаад хөрөнгө оруулалтын позиц</b>	<b>-29,353</b>	<b>-31,553</b>	<b>2,200</b>	<b>7%</b>
<b>I. Гадаад актив</b>	<b>4,309</b>	<b>5,606</b>	<b>1,296</b>	<b>30%</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	455	477	22	5%
2. Багцын хөрөнгө оруулалт	280	260	-20	-7%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	100	00	-100	-100%
4. Бусад хөрөнгө оруулалт	2,178	1,860	-318	-15%
5. Нөөц актив	1,296	3,008	1,712	132%
<b>II. Гадаад пассив</b>	<b>33,662</b>	<b>37,158</b>	<b>3,496</b>	<b>10%</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	16,277	17,245	968	6%
2. Багцын хөрөнгө оруулалт	3,631	4,954	1,323	36%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	116	00	-116	-100%
4. Бусад хөрөнгө оруулалт	13,638	14,959	1,321	10%


Дүрслэл 6. Гадаад актив, пассив



Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2017 оны 4 дүгээр улирал



Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2017 оны 4 дүгээр улирал



### III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өр (хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хөрөнгө оруулалтаас бусад гадаад өр төлбөр)-ийн үлдэгдэл 2017 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар 27,413 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 2,788 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 2,448 сая ам.доллараар нэмэгдэж 7,317 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 234 сая ам.доллараар нэмэгдэж 2,025 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 105 сая ам.доллараар өсч 18,070 сая ам.долларт хүрээд байна.

#### Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2017 оны 4 дүгээр улиралд 2,309 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4%-иар буюу 108 сая ам.доллараар буурчээ.

Гадаад пассивын 42%-ийг урт хугацаат зээл, 26%-ийг бонд өрийн бичиг, 18%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 14%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 978 сая ам.доллар, 411 сая ам.долларт хүрээд байна.

#### Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2017 оны 4 дүгээр улирлын эцэст 15,762 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 214 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 48% буюу 7,572 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.


Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 300 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	16.12.31	17.12.31	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	24,625	27,413	2,788.14	11%	100%
I. Засгийн газар	4,869	7,317	2,448	50%	27%
II. Төв банк	1,791	2,025	234	13%	7%
III. Банк	2,417	2,309.0	-108	-4%	8%
Богино хугацаат	469	0.0	-469	-100%	0%
Урт хугацаат	1,948	0	-1,948	-100%	0%
IV. Бусад сектор	8,121	8,189	68	1%	30%
Богино хугацаат	394	0	-394	-100%	0%
Урт хугацаат	7,727	0	-7,727	-100%	0%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	7,426	7,572	146	2%	28%

\*: Нийт өсөлтөд оруулсан хувь

Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



#### Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

**ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)**

Үзүүлэлт	IV улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2015	2016	2017	Дүн	2016/15	Дүн	2017/16
<b>I. УРСГАЛ ДАНС</b>	<b>-256</b>	<b>17</b>	<b>-617</b>	<b>273</b>	<b>106%</b>	<b>-634</b>	<b>-3813%</b>
Бараа ба үйлчилгээний худалдаа	-130	244	-109	373	288%	-353	-145%
Кредит	1,200	1,715	1,730	515	43%	14	1%
Дебет	1,330	1,472	1,839	142	11%	367	25%
<b>1. Бараа</b>	<b>66</b>	<b>606</b>	<b>322</b>	<b>540</b>	<b>825%</b>	<b>-284</b>	<b>-47%</b>
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,028	1,537	1,521	509	49%	-16	-1%
1.2 Импорт Ф.О.Б (дебет)	963	931	1,200	-31	-3%	268	29%
<b>2. Үйлчилгээ</b>	<b>-195</b>	<b>-362</b>	<b>-431</b>	<b>-167</b>	<b>-86%</b>	<b>-69</b>	<b>-19%</b>
Кредит	172	178	208	6	4%	30	17%
Дебет	367	540	639	173	47%	99	18%
2.1 Тээвэр	-25	-46	-73	-21	-84%	-27	-60%
Кредит	57	67	81	10	17%	14	21%
Дебет	82	113	154	31	37%	42	37%
2.2 Аялал	-46	-73	-86	-26	-57%	-13	-18%
Кредит	59	50	54	-9	-15%	5	9%
Дебет	105	122	140	17	16%	18	14%
2.3 Бусад үйлчилгээ	-124	-244	-272	-120	-97%	-29	-12%
Кредит	56	61	73	6	10%	11	18%
Дебет	180	305	345	125	70%	40	13%
<b>3 Анхдагч орлого</b>	<b>-182</b>	<b>-263</b>	<b>-544</b>	<b>-81</b>	<b>-45%</b>	<b>-281</b>	<b>-107%</b>
Кредит	15	18	19	2	16%	1	7%
Дебет	197	281	563	84	43%	282	101%
3.1 Ажилчдын цалин	-9	-9	-11	-1	-7%	-2	-18%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-173	-254	-536	-81	-47%	-282	-111%
3.3 Бусад	0	0	3	0		3	
<b>4 Хоёрдогч орлого</b>	<b>55</b>	<b>36</b>	<b>36</b>	<b>-19</b>	<b>-35%</b>	<b>0</b>	<b>0%</b>
Кредит	96	66	66	-30	-31%	0	0%
Дебет	41	30	30	-11	-27%	0	0%
Үүнээс: Хувийн гуйвуулга	15	9	9	-6	-40%	0	0%
<b>II. ХӨРӨНГИЙН ДАНС</b>	<b>30</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>-9</b>	<b>-30%</b>	<b>1</b>	<b>4%</b>
<b>1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>		<b>0</b>	
Кредит	0	0	0	0		0	
Дебет	0	0	0	0		0	
<b>2. Хөрөнгийн шилжүүлэг</b>	<b>30</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>-9</b>	<b>-30%</b>	<b>1</b>	<b>4%</b>
Кредит	30	22	22	-8	-27%	1	3%
Дебет	0	1	1	1	231%	0	-14%
<b>Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг +/- зээллэг -)</b>	<b>-227</b>	<b>37</b>	<b>-596</b>	<b>264</b>	<b>116%</b>	<b>-633</b>	<b>-1703%</b>
<b>III. САНХҮҮГИЙН ДАНС</b>	<b>-249</b>	<b>-153</b>	<b>-1,789</b>	<b>96</b>	<b>39%</b>	<b>-1,636</b>	<b>-1067%</b>
<b>Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг +/- зээллэг -)</b>	<b>-249</b>	<b>-153</b>	<b>-1,789</b>	<b>96</b>	<b>39%</b>	<b>-1,636</b>	<b>-1067%</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>-168</b>	<b>-94</b>	<b>-473</b>	<b>74</b>	<b>44%</b>	<b>-379</b>	<b>-404%</b>
1.1 Актив	7	9	17	2	33%	8	84%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	6	9	17	3	46%	8	84%
1.1.2 Өрийн хэрэгсэл	1	0	0	-1	-100%	0	
1.2 Пассив	175	103	489	-72	-41%	386	376%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-27	-47	361	-20	-74%	408	868%
1.2.2 Өрийн хэрэгсэл	202	150	129	-52	-26%	-21	-14%
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>52</b>	<b>24</b>	<b>-393</b>	<b>-29</b>	<b>-55%</b>	<b>-416</b>	<b>-1768%</b>
2.1 Актив	0	0	4	-1	-211%	4	970%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	0	-1	3	-1	-6140%	4	423%
2.1.2 Өрийн бичиг	0	0	1	0	17%	1	
2.2 Пассив	-52	-24	397	28	54%	421	1753%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	2	0	-1	-3	-113%	-1	-265%
2.2.2 Өрийн бичиг	-54	-24	398	31	56%	422	1780%
<b>3. Санхүүгийн үсмэл хэрэгслүүд</b>	<b>-2</b>	<b>39</b>	<b>0</b>	<b>41</b>	<b>2083%</b>	<b>-40</b>	<b>-101%</b>
3.1 Актив	-5	-25	-1	-19	-354%	24	98%
3.2 Пассив	-3	-64	0	-60	-1748%	64	100%
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>-132</b>	<b>-122</b>	<b>-923</b>	<b>10</b>	<b>7%</b>	<b>-801</b>	<b>-655%</b>
4.1 Актив	5	-214	-359	-218	-4521%	-146	-68%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	27	-246	-360	-273	-1018%	-114	-46%
4.1.3 Зээл	0	0	2	0	215%	2	2024%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-22	32	-2	54	248%	-34	-106%
4.1.5.1 Богино хугацаат	-22	32	-2	54	248%	-34	-106%
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0		0	
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	137	-91	564	-228	-167%	655	719%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	-193	100	-9	293	152%	-109	-109%
4.2.3 Зээл	290	-117	579	-407	-140%	696	596%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0		0	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	162	-117	-11	-279	-172%	106	91%
4.2.3.3.1 Богино хугацаат	115	-43	-49	-158	-137%	-5	-13%
4.2.3.3.2 Урт хугацаат	47	-74	38	-121	-259%	112	151%
4.2.3.2 Засгийн газар	162	125	581	-37	-23%	456	366%
4.2.3.4 Бусад салбар	-34	-124	9	-90	-265%	133	108%
4.2.3.4.1 Богино хугацаат	-14	-74	-59	-60	-438%	15	21%
4.2.3.4.2 Урт хугацаат	-20	-50	68	-30	-148%	118	237%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	20	-74	-6	-94	-480%	68	91%
4.2.5.1 Богино хугацаат	20	-62	-6	-82	-419%	56	90%
4.2.5.2 Урт хугацаат	0	-12	0	-12		12	100%
4.2.6 Бусад авлага	20	0	0	-20	-100%	0	
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0		0	
<b>IV. Алдаа болон орхигдуулга</b>	<b>-118</b>	<b>23</b>	<b>65</b>	<b>142</b>	<b>1</b>	<b>42</b>	<b>2</b>
<b>V. НӨӨЦ ХӨРӨНГӨ</b>	<b>-96</b>	<b>214</b>	<b>1,258</b>	<b>310</b>	<b>324%</b>	<b>1,044</b>	<b>488%</b>
1. ГВУН	-96	214	1,337	310	324%	1,123	525%
2. ОУВС-гийн зээл	0	0	79	0		79	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	





**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР ( сая ам.доллар)**

<b>Үзүүлэлт</b>	<b>12/31/2010</b>	<b>12/31/2011</b>	<b>12/31/2012</b>	<b>12/31/2013</b>	<b>12/31/2014</b>	<b>12/31/2015</b>	<b>12/31/2016</b>	<b>03/31/2017</b>	<b>06/30/2017</b>	<b>09/30/2017</b>	<b>12/31/2017</b>
Засгийн газар	1,882.2	2,043.3	3,599.3	3,534.6	3,500.8	3,759.9	4,868.6	5,844.6	6,016.2	6,241.0	7,317.1
Төвбанк	273.6	267.7	571.5	1,130.5	1,570.4	1,959.6	1,790.8	1,741.0	1,870.8	1,904.0	2,025.1
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	512.0	739.8	1,176.0	1,375.8	1,762.2	2,128.5	2,417.4	2,382.5	2,270.2	2,342.4	2,309.0
Бусад салбарууд	1,474.3	1,904.7	2,836.1	3,198.7	3,976.6	3,748.9	8,121.5	7,464.4	7,885.2	8,092.7	8,189.4
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	2,985.7	5,952.8	9,027.6	10,590.1	11,040.6	11,120.9	7,426.3	7,525.0	7,172.5	7,443.5	7,572.1
<b>Нийт гадаад өр</b>	<b>7,127.8</b>	<b>10,908.3</b>	<b>17,210.5</b>	<b>19,829.7</b>	<b>21,850.5</b>	<b>22,717.8</b>	<b>24,624.5</b>	<b>24,957.4</b>	<b>25,214.9</b>	<b>26,023.6</b>	<b>27,412.6</b>